




**УЛЗ ГОЛЫН САВ ГАЗАРТ УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН ОНЦГОЙ
БОЛОН ЭНГИЙН ХАМГААЛАЛТЫН БҮСТЭЙ ДАВХЦАЛТАЙ
ОЛГОГДСОН АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛ, АШИГЛАЛТЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ТАЛБАЙ ДЭЭР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА
ХЭМЖЭЭ, ОЛОЛТ АМЖИЛТ, ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ, ЦААШИД
АНХААРАХ АСУУДАЛ**

*Б.Баяртогтох, Онон-Улз голын сав газрын захиргааны дарга
2019 оны 1-р сарын 30, Тэрэлж, Улаанбаатар*


Улз голын сав газар
нь Дорнод, Хэнтий
аймгийн 11 сумын
38000 км.кв талбай
нутаг дэвсгэр
хамарсан талбай
Юм.

Улз голоо дагасан 4 суманд сав газрын хэмжээгээр 11.324 хүн ам, 700.379 толгой мал байна.

3.1.3. “усны сав газар” гэж гадаргын ус хурах талбай болон газрын доорх усны нөөцийг бүрдүүлэх тэжээгдлийн муж, тархалтын талбайг хамарсан орон зайг



УЛЗ ГОЛЫН ГОЛДРИЛ



2018.07.17 сар Гурвагзагал, Чулуунхороот сумын хилийн зааг Хадан хошуунд тасарсар байсан. Улз голын урсаж байгаа хэсэг нь 447,9 км ширгэсэн хэсэг нь 47,9 км байна. Голын нийт урт нь 495 км.

2018.10.10 Чулуунхороот сум Дөрөө нуураас цааш 1км урсаад тасарч байна. Улз голын урсаж байгаа хэсэг нь 465,9 км ширгэсэн хэсэг нь 29,1 км байна. Голын нийт урт нь 495 км.

2017,10 сарын хэмжилтээр тасарсан цэг. Улз голын урсаж байгаа хэсэг нь 432.1 км ширгэсэн хэсэг нь 62,9 км байна. Голын нийт урт нь 495 км.

Таних тэмдэг

■ 2017 онд хэмжилт хийсэн цэг

■ 2018 оны 07 сард хийсэн хэмжилтийн цэг

■ 2018 оны 10 сард хийсэн хэмжилтийн цэг тасарсан цэг

— Голын голдрил

M1:100 000

Coordinate System: WGS 1984 UTM Zone 49N
Central Meridian: 111°0'0"E

САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

- Усны тухай хуулийн 17 дугаар зүйлд:
- 17.1.3. Бүх шатны Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг мэргэжлийн зөвлөмжөөр хангах;
- 17.1.4. Усны тоо бүртгэлийг жил бүр сав газрын хэмжээнд нутгийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах;
- 17.1.5. Сав газрын усны мэдээллийн дэд санг эрхэлж, олон нийтийг мэдээллээр хангах;
- 17.1.6. Ус ашиглах зорилгоор цооног өрөмдөх, суваг хоолой татах тухай иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч, усны нөөцийн менежментийн төлөвлөгөөг үндэслэн энэ хуулийн 28.4-т заасны дагуу ус ашиглуулах дүгнэлт гаргах, мэдээллийн санд оруулж бүртгэх;
- 17.1.7. Ус ашигласны болон бохирдуулсны төлбөрийг зохих хууль тогтоомжийн дагуу ногдуулах үндэслэлийг тодорхойлох;
- 17.1.9. Ус ашиглах, хаягдал ус зайлуулах шаардлагыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглах, хаягдал ус зайлуулах эрхийг цуцлах дүгнэлт гаргах, байгальд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах;
- 17.1.10. Сав газрын хэмжээнд ашиглах боломжит усны нөөц, ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж ажиллах;
- 17.2. Тухайн сав газарт ашигт малтмалын хайгуул хийх, олборлолт явуулах тусгай зөвшөөрөл олгоход тус сав газрын захиргааны саналыг үндэслэнэ.

2017 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/270

Чойбалсан

Ажлын хэсэг байгуулж, журам
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 12.1.4, Байгаль орчин, Ногоон хөгжил, Аялал жуулчлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын хамтарсан 2015 оны А-230/127 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн хориглолт ба хязгаарлалтын бүсийг тогтоох санал боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Ажлын хэсгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж орон нутагт ажиллуулан, нэгдсэн санал дүгнэлтийг 9 дүгээр сарын 25-ны дотор аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын орлогч /Ч.Ганбат/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА М.БАДАМСҮРЭН

Аймгийн Засаг даргын 2017 оны
05 дугаар сарын 31-ний өдрийн
А/270 дүгээр захирамжийн
нэгдүгээр хавсралт


АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	Ч.Ганбат	-Дорнод аймгийн Засаг даргын орлогч
Ажлын хэсгийн дэд дарга:	Х.Энх-Отгон	-Аймгийн Засаг даргын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	А.Гантулга	-Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга
Гишүүд:	Д.Дамдинбазар	-Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга
	Ж.Алимаа	-Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	М.Алтаннавч	-Ус, цаг уур орчны шинжилгээний газрын дарга
	Ш.Хангарьд	-Буйр нуур, Мэнэнгийн талын сав газрын захиргааны дарга
	Д.Жамбаа	-Хэрлэн голын сав газрын захиргааны дарга
	Б.Баяртогтох	-Онон-Улз голын сав газрын захиргааны дарга
		-Сумдын Засаг дарга нар

Дорнод аймгийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/270 тоот захирамжаар аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбатаар даргалуулсан аймгийн нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн хориглолт ба хязгаарлалтын бүсийг тогтоох санал боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлуулсан.



- Усны тухай хуулийн 13.1.6, 17.1.4 дэх заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16.2.3. дахь заалт, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаалаар баталсан журам, Аймгийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн А/270 тоот захирамжийн дагуу Монгол Улсын гадаргын усны сүлжээ, байр зүйн зураг, сансарын хиймэл дагуулын өндөр нарийвчлал бүхий зургийг ашиглан Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2-т заасны дагуу усны сан бүхий газрын эргээс 50м-т болон түүнээс өргөн татамтай тохиолдолд байгалийн татмын хилийг тодорхойлон **онцгой хамгаалалтын бүсийг 273636.2 га** талбайд, Усны тухай хуулийн 22.3-т заасны дагуу **энгийн хамгаалалтын бүсийг 369400.9 га** талбайд тогтоохоор зураглалыг боловсруулаад байна.
- Хамгаалалтын бүсийн зураглалын ажил БОАЖЯ-ны Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого, зохицуулалтын газарт хянагдаж, 2018 оны 11 сарын 27-ны 09/8384 тоот албан бичгээр дүгнэлт ирүүлсэн.



УСНЫ САН БҮХИЙ ГАЗАР ГЭЖ ЮУ ВЭ

Усны тухай хуулинд:

3.1.4. “усны сан бүхий газар” гэж нуур, цөөрөм, тойром, гол мөрөн, горхи, булаг, шанд, усан сан, рашаан, намаг, мөстөл, мөсөн голын эзэлж байгаа талбай, тэдгээрийн хамгаалалтын бүсийн газрыг; хэлнэ гэж заасан байдаг.

- **Усны сан бүхий газар гэдэг нь дор хаяж урин дулааны улирлын тодорхой үед хөрсийг ус бүрхдэг эсвэл газрын гадарга дээр үгүй бол гадаргад ойрхон ус илэрдэг газрыг хэлнэ.**

ОНЦГОЙ ХАМГААЛАЛТЫН БҮС

- 2012 онд батлагдсан Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2. Усны сан бүхий газрын эргээс 50 метрээс доошгүй зайд болон гол мөрний татамд онцгой хамгаалалтын бүс тогтооно.

- *Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан*

УСНЫ САН БҮХИЙ ГАЗАР, УСНЫ ЭХ ҮҮСВЭРИЙН ОНЦГОЙ БОЛОН ЭНГИЙН ХАМГААЛАЛТЫН, ЭРҮҮЛ АХУЙН БҮСИЙН ДЭГЛЭМИЙГ МӨРДӨХ ЖУРАМ”-ын

2.3.2.гол мөрөн, горхи, булаг, шандын эргээс 50 метрээс доошгүй зайд буюу түүнээс өргөн, намаг бүхий татамтай тохиолдолд нийт татмын хэмжээгээр өргөсгөж;



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД,
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2015 оны 6 дугаар сарын 05-ны өдөр

Дугаар А-230/127

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.“Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү журмын хэрэгжилтийг харьяалах нутаг дэвсгэрт зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгож, хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөсүгэй.

3.Журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны Газар зохион байгуулалт болон усны нэгдсэн бодлого зохицуулалтын газар /Г.Мөнх-Эрдэм/, Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар /Г.Нямдаваа/ болон Газрын харилцаа, геодези, зурагзүйн газар /А.Хүрэлшагай/-т тус тус үүрэг болгосугай.

4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Дэглэм батлах тухай” Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2009 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 51/75 дугаар тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД


Д.ОЮУНХОРОЛ

Д.ЦОГТБААТАР

УСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН НЭР ТОМЪЁОНД: 3.1.34. “ГОЛ МӨРНИЙ ТАТАМ” ГЭЖ ГОЛЫН ГОЛДИРЛЫН ЭРГЭЭС ЭХНИЙ ДЭНЖ ХҮРТЭЛХ НУГЫН ЗУРВАС БҮСИЙГ ХЭЛНЭ ГЭЖ ЗААСАН БАЙДАГ.



Гол, мөрний татмын хуулийн тодорхойлолтоор гурван нөхцөл хангагдах ёстой гэж үзэж байгаа. Үүнд:

- Гидрофит/усанд ургадаг ургамал байх
- Гидрид/ усархаг, хүчилтөрөгчөөр дутмаг хөрс
- Гидрологийн/ус судлалын эерэг баталгаажуулалт



Усан сан бүхий газрын гидрологийн шинж тэмдэгүүд

- Усан бүрхүүлтэй
- Ул хөрсний ус газрын газаргад ойрхон, гүехэн хэсэгт устай
- Усархаг
- Уснаас үүдэлтэй чулуулагийн хэлтэрхийн давхарга үүссэн
- Уснаас үүдэлтэй тунадасны хуримтлал үүссэн
- Усны сан бүхий газрын хүрээнд гуу жалгатай
- Усны толботой навчис
- Ургамлын бүтцийн өөрчлөлт
- Үндсэн төрөл зүйлийн ихэнх нь усархаг нөхцөлд ургадаг ургамал




- Татам, усны сан бүхий газар нь шүүлтүүрийн үүрэг гүйцэтгэж усыг цэвэршүүлдэг.
- Татам, усны сан бүхий газар нь тунадасыг шингээж хугацааны эрхээр бохирдол задрах боломжийг бүрдүүлдэг.
- Борооны ус газрын доорх усан давхаргад хуримтлагддаг.
- Ган ганчиг, өвлийн улиралд малын бэлчээр болдог.
- Олон ургамал, амьтны ялангуяа ховордсон төрөл зүйлийн гэр орон болдог.
- Дулаан тусгаарлагчийн үүрэг гүйцэтгэж мөнх цэвдэг хайлахаас хамгаалдаг
- Үерийн урсгалыг бууруулдаг
- Ган ганчигийн үеэр гол, горхийн урсгалыг хадгалж байдаг.
- Дэд бүтцийг үерийн эвдрэлээс хамгаалж байдаг



2. АЖЛЫН ХЭСГИЙН ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД



“Дорнод аймгийн хэмжээнд усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн хилийг зураглах” уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж олон талын оролцоог хангаж ажилласан.



Сав газрын захиргаад уст цэгийн тоо бүртгэлийн 2011, 2015, 2017 оны дүн, байрзүйн зураглал, хиймэл дагуулын зураглал, Монгол орны хэмжээнд гол нуурын эрэг орчмын ус намгархаг газар, татмын байгалийн хилийг зурагласан ажлын тайланг үндэслэн зайнаас тандан судлах аргыг ашиглаж суурин боловсруулалт хийсэн.



Сав газарт хамаарагдах сумдад Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн хилийг урьдчилан зурагласан үр дүнг баталгаажуулах, орон нутгийн удирдлагуудын саналыг үндэслэн засварлах зорилгоор хээрийн хэмжилтийн ажлыг зохион байгуулсан.




Зураглалын ажлыг Аймгийн хэмжээнд олгогдсон ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл, газар тариалан, аялал жуулчлалын зориулалтаар олгогдсон газар, сум суурьшлын бүсийн хилтэй давхцуулж давхцалын хэмжээг гаргасан.




Усны тухай хуулийн 11.4 дэх хэсэгт заагдсаны дагуу Байгаль орчин, Аялал жуулчлалын яамны 2018.11.27-ны 09/8384 дүгнэлтийг үндэслэн ИТХ-д танилцуулах

УЛЗ ГОЛЫН САВ ГАЗАР – АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

- Тус сав газарт 2018 оны 12 сарын байдлаар хайгуулын 75, ашиглалтын 42 тусгай зөвшөөрөл олгогдоод байна.
- Үүнээс: 6601.1га талбай бүхий 2 хайгуулын тусгай зөвшөөрөл, 212.9га талбай бүхий 1 ашиглалтын тусгай зөвшөөрөл сав газарт хамаарах Хэнтий аймгийн нутагт, 262169.3га талбай бүхий 73 хайгуулын тусгай зөвшөөрөл, 22216.6га талбай бүхий 41 ашиглалтын тусгай зөвшөөрөл сав газарт хамаарах Дорнод аймгийн нутагт тус тус байрлаж байна.
- Энэхүү хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн нийт хэмжээ 291199.9га талбай байна.



Улз голын сав газрын ашигт малтмалын мэдээлэл




Ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо



■ усны сан бүхий газартай давхцалгүй ■ усны сан бүхий газартай давхцалтай

Хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо





■ усны сан бүхий газартай давхцалгүй ■ усны сан бүхий газартай давхцалтай

Үзүүлэлт	Дорнод аймгийн хэмжээнд сав газрын хилээр					
	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо	Хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо	Нийт	Усны сан бүхий газартай давхцалтай ашиглалтын талбай	Усны сан бүхий газартай давхцалтай хайгуулын талбай	Нийт
тоогоор	41	73	114	19	41	60
га-аар	22216.6	262169.3	284385.9	765.8	5071.6	5837.4

Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т заасны дагуу Улз голын сав газрын хэмжээнд 153 хайгуулын талбайн өргөдөл ирсэнг Усны сан бүхий хамгаалалтын бүсийн зураглалтай давхцуулан нийт 68 талбайг давхцалтай байна гэсэн лавлагаа гаргаж өгсөн.


Баяндун суманд 19 талбай, Баян-Уул суманд 25 талбай, Гурванзагал суманд 6 талбай, Дашбалбар суманд 10 талбай, Чойбалсан суманд 5 талбай, Чулуунхороот суманд 2 талбай давхцалтай гэсэн лавлагаа гаргасан.



- 2018 онд БОАЖЯ-ны захиалгаар Хэнтий аймгийн Биндэр суманд Хөмүүл гол дээр хайгуулын 1 талбай, Дорнод аймгийн Дашбалбар суманд Сэвсүүл гол дээр хайгуулын 1 талбай, Баяндун сумын Засаг даргын захиалгаар хайгуул хийх хүсэлт гаргасан 2 талбай, ОХУ-аас урсан орж ирдэг Их Нэргүйн гол, Улз голын хойд биед 2 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай дээр, Тэмээн уул нөхөрлөлийн ахлагч, иргэн Ч.Энхээгийн хүсэлтээр Зүрхийн булаг дээр хайгуулын 1 талбай дээр хээрийн хэмжилт хийж, лавлагаа гарган хүргүүлсэн.
- 2019 онд Хэнтий аймгийн Батширээт сумын Улаанбаатар хот дахь Нутгийн зөвлөлийн албан хүсэлтээр Баруун гутайн гол, Зүүн Гутайн голын мэдээллийг боловсруулж байна.



УЛЗ ГОЛЫН УРСАЦ БҮРЭЛДЭХ ЭХИЙН ХИЛИЙН ЗААГИЙГ ТОДОРХОЙЛОХ АСУУДАЛ




1 дүгээр зураг:


Засгийн газрын 2012 оны 06 сарын 194 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар Монгол Улсын нутаг дэвсгэр дэх гол, мөрний урсац бүрэлдэх эхийн хилийн заагийг тогтоосон байдаг.

2 дугаар зураг:

Дэлхийн Байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Газарзүй –Геоэкологийн хүрээлэнтний хамтран Улз голын урсац бүрэлдэх эхийг шинээр тооцож үзсэн байдал.

3.1.5."гол, мөрний урсац бүрэлдэх эх" гэж гадаргын урсацын үндсэн хэсэг бүрэлдэн бий болдог өндөр уулсын бүс, сав газрын эхийг;



The background is a blue gradient. In the corners, there are white line art illustrations of circuit boards or neural networks, with lines connecting to small circles.

ДӨЧ ГОЛ – ХӨӨСГӨЛ ХХК

Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль

4.1.Монгол Улсын нутаг дэвсгэр дэх гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглоно.


4.2.Энэ хуулийн 4.1 дэх хэсэг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамаарахгүй.

4.3.Энэ хуулийн 4.1-д заасан газрын хилийн заагийг Засгийн газар тогтооно.

ЗАСГИЙН ГАЗРЫН 289 ДҮГЭЭР ТОГТООЛ

Усны сан бүхий газрын эргээс 50 метрт онцгой, 200 метрт энгийн хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх ажлыг 2015 оны 10 сард багтаан зохион байгуулахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай






Хөөсгөл ХХК-ийн талбай дээр тулгарч буй бэрхшээл

1. Дөч гол нь ОХУ-аас эх аван Дорнод аймгийн Баяндун сумын нутгаар урсан орж ирж, Дашбалбар сумын нутагт Улз гол цутгадаг, Улз голын томоохон цутгал гол юм. Гэтэл сүүлийн жилүүдэд Улз гол цутгадаг хэсгээсээ 10 орчим км-ын өмнө шургаж тасарч байна.
2. Тус талбайд 1998 оноос эхлэн уул уурхайн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулахдаа шууд гол дотор, голын голдрил өөрчлөн алт угааж байсан баримтууд байдаг.
3. 2018 онд Нуман алтай ХХК-иар байгаль орчинд учруулсан хохирол тооцох явцад 2004, 2008, 2010 онд голын голдрилд ихээхэн хэмжээний өөрчлөлт орсон байсан.
4. 2010 онд алтны шламаа алдаж Дөч голоор урсаж, Дашбалбар сумын иргэдээс гомдол ирсэн тул уурхайг тойруулан шуудуу татаж голын голдрил өөрчилсөн байдаг.
5. Голын голдрил ихээхэн өөрчлөгдсөн тул АМГТГ, БОАЖЯ-ны мэдээллийн сантайгийн мэдээлэлтэй зөрчилдөж, голын голдрил ашиглалтын талбай руу орж, гарч яваад байна.
6. Үүнээс болоод уурхайн олборлолт усаа дийлэхгүй нөхцөл байдал үүссэн. Голын голдрил дахин өөрчлөгдөх нөхцөл байдал үүссэн.
7. Монгол Ус ТӨААТҮГ, Геодиз зураг зүйн “Мон Мап” ХХК-тай хамтран голын голдрилын үнэн зөв дүр төрхийг тодорхойлох ажил 2017 оноос эхлэн хийгдэж байна.







Хөөсгөл ХХК-ийн олборлолтын үед усны сан бүхий газар, ойн сан бүхий газар хөндөгдөж байна гэж орон нутгийн удирдлага, нутгийн иргэд үзэж байна.



2 дугаар зураг Дөч голын татмын байгалийн хил буюу онцгой хамгаалалтын бүстэй давхцалтай хэсэг



1 дүгээр зураг Баяндун сумын 2010 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 38 тоот захирамжаар батлагдсан энгийн хамгаалалтын бүстэй давхцалтай хэсэг



- 2016 оны 04 сарын 04-ний өдөр Баяндун сумын Засаг даргын А/24 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж зураглалын ажлын хийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 06 сарын хуралдаанаар сумын томоохон голуудад усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс тогтоосон.

- Тус талбайд Баяндун сумын Засаг дарга Б.Баатарцогтын 2010 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 38 тоот захирамжаар голын эргээс 500-1000м-т энгийн хамгаалалтын бүс тогтоосон байна. Дээрх захирамжаар 2010 оны захирамж хүчингүй болсон.


ДОРНОД АЙМАГ
БАЯНДУН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2016 оны 04 сарын 04 өдөр
Дугаар А/24

Наран бузар

Бүс тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын А-230/127 тоот хамтарсан тушаалаар батлагдсан "Усан сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам"-ын 2.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баяндун сумын нутаг дэвсгэр дэх усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, эх үүсвэрт онцгой болон энгийн хамгаалалтын эрүүл ахуйн бүс тогтоож, тэмдэгжүүлэх ажлын хэсгийг доорхи бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.	
Ажлын хэсгийн ахлагч	-Л.Батчулуун
Гишүүд	-Б.Баяртогтох
	-Т.Бямбажаргал
	-И.Алтмаа
	-С.Алтансүвд
	-Ч.Баттэмжүүжин
	-Т.Ганбаатар
	-Б.Цэцэгтогтох
	-Ц.Дашдорж
	-Н.Энхтайван
	-Б.Долгорсүрэн
	-Х.Хүрэлчулуун
	-Б.Баттөмөр

Засаг даргын орлогч
Улз голын сав газрын захиргааны дарга
Улз голын сав газрын захиргааны мэргэжилтэн
Улз голын сав газрын захиргааны мэргэжилтэн
Байгаль орчны хяналтын улсын байцаагч
Газрын даамал
Байгаль хамгаалагч
Байгаль хамгаалагч
Байгаль хамгаалагч
Түргэн багийн Засаг дарга
Хайрхан багийн Засаг дарга
Яргай багийн Засаг дарга
Наран багийн Засаг дарга


2.Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн хэрэгжилтэнд байнгын хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга нар болон Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Байгаль хамгаалагч нарт үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2010 оны 38 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА
Б.БАТЖАВ

2016.04.04 №А/24
Хөтлөх хэрэг 1-1


C:\My Documents\Zahramj-

The background is a blue gradient. In the corners, there are white line art illustrations of circuit boards or neural networks, with lines connecting to small circles.

ИХ НЭРГҮЙН ГОЛ – ЦЦ ЭРДЭС МАЙНИНГ ХХК

• Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны 2014 оны 03 сарын 10-ны өдрийн 6/1179 албан тоотоор тухайн үед ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаа явуулж байсан XV 014504 тусгай зөвшөөрөлтэй Дорнод Хажир ХХК-ийн Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэх хүсэлтэд Усны сан бүхий газрын хилийн заагтай давхцаж байгаа тул ерөнхий үнэлгээ хийх боломжгүй байна гэсэн ерөнхий шинжээч Д.Энхбатын хариу тайлбар хүргүүлж байсан байна


ИХ НЭРГҮЙН ГОЛ – ЦЦ ЭРДЭС МАЙНИНГ ХХК



ИХ НЭРГҮЙН ГОЛ – ЦЦ ЭРДЭС МАЙНИНГ ХХК

Хээрийн судалгаа: Хээрийн судалгааг “Эко хайрхан” ХХК-ийн захирал, экологич С.Дашзэвэг, GIS инженер Б.Даваажаргал, ургамал судлаач доктор Д.Зоёо, хөрс судлаач доктор, профессор С.Хадбаатар нарын бүрэлдэхүүнтэй хийж гүйцэтгэв.

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ЦЦ ЭРДЭС МАЙНИНГ” ХХК-ИЙН
“ИХ НЭРГҮЙН АМ БА ТҮҮНИЙ БАРУУН САЛААНЫ АЛТНЫ ШОРООН ОРД АШИГЛАХ” ТӨСЛИЙН
ТАЛБАЙН ГЕОМОРФОЛОГИЙН ЗУРАГ



Чулуулагт талбайн хэмжээнд тархсан дөч гол болон зүрх толгой формацийн хурдсууд хамаарах ба ус агуулагч чулуулгууд нь голчлон янз бүрийн ширхэгтэй полимикт элсэн чулуу, гравелит, конгломерат ховроор алевролитийн үеүд байдаг.

Чулуулагт агуулагдаж буй усны эргэлт болон хуримтлал тэдгээр чулуулаг дахь олон тооны ан цав, нүх сүвээр хянагдах ба заримдаа эдгээр ан цавууд газрын гадаргуугаас нилээд их гүнд ч үргэлжилдэг. Газрын доорхи усны тэжээл голлон хур тундасны усаар тэжээгдэх ба бага хэмжээгээр агаарын чийгээр тэжээгдэнэ. Тэдгээр нь гадаргууд булаг горхи хэлбэрээр илрэх ба Их нэргүй горхины хөндийн эхэнд Оросын холбооны улсын нутагт ижил нэртэй горхи урсдаг.

Их горхины гадаргууд илэрч урсаж байгаа байдал болон геологийн тогтоцоос харахад ОХУ-аас урсан ирж байсан горхи судалгааны талбайгаас хойш 2км орчимд шургаж алга болдог ба энэ хэсэгт Дөч гол, Зүрх толгой формацийн хурдсуудыг зааглаж буй өргөрөгийн багуу болон зүүн хойш чиглэлтэй томоохон тектоник хагарлын бүс үргэлжилж байдаг.

Хөндлөн-Уулын алтны шороон ордны хуримтлал Их нэргүй горхины хөндийн дунд доод хэсэг, баруун болон зүүн салаа амуудын хэмжээнд тогтоогдсон байна. Геологийн тогтоцын хувьд ордын байрлах хэсэгт Перм-доод Триасын (P3 T2 Dg) дээд Юрагийн (J3Zt) Дөрөвдөгчийн (Q1Q2diplQ2) гол формацын чулуулаг тархсан.

Чулуулгууд нь ихэвчлэн цайвар ногоон, ногоон саарал өнгийн том жижиг ширхэгтэй элсэн чулуу конгломерат, цахиурлаг алевролит, аргелит, занар, полимент элсэн чулуу

ИХ НЭРГҮЙН ГОЛ – ЦЦ ЭРДЭС МАЙНИНГ ХХК



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Барилгачдын талбай 3, Утас: 26 22 70,
Факс: (976-11) 32 26 83, E-mail: info@gazar.gov.mn

2018.06.14 № 1/1084

төрийн 2018.06.14-ны № 4-55/18 -т

"ЭКО ХАЙРАН" ХХК-д

Дүгнэлт баталгаажуулсан тухай

Монгол Улсын "Газрын тухай хууль"-ийн 58 дугаар зүйл, Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журмын"-ын 3.6-д заасны дагуу "ЦЦ ЭРДЭС МАЙНИНГ" ХХК-ын захиалгаар танай компаний хийж гүйцэтгэсэн Дорнод аймгийн Баяндун суманд байрлах ашигт малтмал ашиглалтын MV-020507 тоот тусгай зөвшөөрөлтэй газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын дүгнэлтийг баталгаажуулан хүргүүлэв.

Хавсралт 3 хуудастай.

ДАРГА

Ц.ГАНХҮҮ



0801801897

Ургамлан бүрхэвчийн төлөв байдал

Бэлчээрийн хэв шинж	Ургамлан бүрхэвчийн төлөв байдал							
	10 м ² талбайд тархах зүйлийн тоо	1 м ² талбайд тархах зүйлийн тоо	Тусгаг бүрхэц (%)	Бэлчээрийн талхагдлын илтгүүр зүйлийн эзлэх %	Хагд (%)	Халцгай газар (%)	Хад чулуу	Ургац, ц/га
Зүр өвс-Алаг өвст	23	15	70	10-15	5	10	3	5

Уг бүлгэмдэл нь уурхайн үйл ажиллагаагаар олборлолтонд өртөж талхлагдаж байгаа бэлчээр болно.

12. Газар ашиглалтын аюулгүй байдал, техникийн нөхцөл: Төслийн техник, технологийн горимыг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд заасны дагуу стандартыг мөрдөж ажиллах хэрэгтэй.

13. Газрын төлөв байдал, чанарын өөрчлөлтийн талаар хийсэн дүгнэлт, цаашид өгөх зөвлөмж:

Тус ордод өмнө нь олборлолт явагдаж байсан бөгөөд "ЦЦ эрдэс майнинг" ХХК манайх үйл ажиллагаа явуулаагүй урьд нь өөр компани олборлолт явуулсан гэж тайлбарласан.

Тус ордод уурхайлалт явагдаж байсны улмаас 22.26 га талбай ухагдаж, 8.23 га талбай овоолгод дарагдаж, баяжуулах үйлдвэр, нуур зэргээр нийтдээ 37.28 га талбай эвдрэлд орж газрын гадарга, хөрсний үндсэн хэвшинж өөрчлөгдөж, ургамлан нөмрөг устсан байна. Иймд "ЦЦ эрдэс майнинг" ХХК нь дахин ашиглахгүй нөлөөлөлд өртөгдсөн газрын гадарга, хөрс, ургамлын анхны хэв шинж, төлөв байдлыг орчны нөхцөлтэй дүйцүүлэн техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийх шаардлагатай. Цаашид олборлолт, үйл ажиллагаанд өртөх талбайг ашиглаж дууссан тухай бүр нөхөн сэргээх шаардлагатай.

Нөхөн сэргээлтийг хийхдээ мэргэжлийн байгууллага, мэргэжлийн хүнээр "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008", "Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх MNS 5917:2008", "Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2008" стандартууд болон Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А-138 дугаар тушаалаар батлагдсан "Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал"-ын дагуу хийх нь зүйтэй.

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
УЛСЫН ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ

Ц.ГАНХҮҮ





МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр.
Утас: 26 19 86. Факс: (976-51) 26 61 71.
E-mail: contact@mne.gov.mn, http://www.mne.mn

2019.12.19 № С.66/9913
танай _____-ны № _____-т

ЦЦ ЭРДЭС МАЙНИНГ ХХК - Д

Дорнод аймгийн Дашбалбар сумын нутагт орших
MV-020507 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл нь:

"Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай" хуулийн 4.3 - т заасан Засгийн газрын 2012 оны 194 дүгээр тогтоолоор баталсан /Засгийн газрын 2015 оны 289 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон/ гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүс, ойн сан, Улсын тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй байна.

Зурган мэдээллийг хавсаргав.

ОЙ, УС, ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ
ГАЗРЫН КАДАСТРЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Н.БАТЗАЯА



ХЭСЭГЧИЛСЭН ХАСАЛТ
ХИЙГДЭЖ, УСНЫ САН
БҮХИЙ ГАЗАРТАЙ
ДАВХЦАЛГҮЙ ГЭЖ ҮЗЭН
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ОЛГОГДСОН.





- 2018 оны 07 дугаар сарын 20-ны өдөр ОХУ –ын нутгаас Дорнод аймгийн Баяндун сумын хилийн заагаар урсан орж ирдэг Их нэргүйн голын татмын дагуу хээрийн хэмжилт хийхээр Онон-Улз голын сав газрын захиргааны ахлах мэргэжилтэн Н.Энхтайван мэргэжилтэн Б.Баатарсүрэн, Т.Бямбажаргал, Б.Ууганбаяр, Тохторын заставын дарга хошууч Г.Мөнхтөр, ахлах ахлагч н.Амарболд нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажиллалаа.



- голын адаг хэсгээс дээш голын татмын дагуу 2 улсын хилийн зааг хүртэл $49^{\circ} 57' 40.6''$; $113^{\circ} 32' 23.8''$ / нийт 149 цэг дээр хээрийн хэмжилтийг хийсэн. Бороо ус ихтэй байгаа тул их талиан үүсгэж урсаж байсан. Мөн Их нэргүйн голын урсацыг доорхи 4 цэг дээр хэмжлээ.



Хэмжилт 1 Их нэргүй голын эхэн хэсэг уурхайн канам татсан дээд цэгт хэмжив.

Солбицол: $113^{\circ} 32' 28.6''$ $49^{\circ} 57' 18.3''$

Голын өргөн -0.67м

Урсгалын хурд-0.65 м/с

Дундаж гүн- 0.31м

Голын дундаж урсац - 0.11 м³/с

Хэмжилт 2 Их нэргүй голын дунд хэсэг уурхайн канам татсан шугамаас доош хэмжив.

Солбицол: $113^{\circ} 32' 43.7''$ $49^{\circ} 57' 42.1''$

Голын өргөн -0.66м

Урсгалын хурд-0.35 м/с

Дундаж гүн 0.35

Голын өнгөрөлт-0.07м³/с

Хэмжилт 3 Их нэргүй голын шургаж байгаа хэсэгт урсац хэмжив.

Солбицол: $49^{\circ} 54' 0.6''$; $113^{\circ} 40' 26.7''$

Голын өргөн -1м

Урсгалын хурд-0.42 м/с

Дундаж гүн 0.23м

Голын өнгөрөлт-0.04 м³/с

Хэмжилт 4 Их нэргүйн ус, Далан тавын хөндийн гол хоёрын уулзвар дээр урсац хэмжив.

Солбицол: $49^{\circ} 54' 11.2''$; $113^{\circ} 6.3''$

Голын өргөн -1.1м

Урсгалын хурд-0.23 м/с


Дундаж гүн 0.04м

Голын өнгөрөлт-0.01 м³/с



ИХ НЭРГҮЙН ГОЛ – ЦЦ ЭРДЭС МАЙНИНГ ХХК

- Их нэргүйн гол нь Далан тавын хөндийн голтой нийлж Дөч голд цутгадаг. Далан тавын хөндийн голыг нутгийн иргэд Хөх чулуутын гол гэж нэрлэж байсан. Их Нэргүйн гол нь Дөч голтой нийлдэг хэсэгтээ голдрил ялгахааргүйгээр тэгш тал болсон байсан.
- Далан тавын хөндийн гол болон Их нэргүйн гол нь 2015, 2017 оны усны тоо бүртгэлээр устай гэж бүртгэгдсэн. 2017 оны усны тоо бүртгэлийн мэдэллийг сум орон нутгийн холбогдох мэргэжилтнүүдтэй холбогдож аман байдлаар мэдээллээ нэгтгэсэн тул урсацын хэмжилт хийгээгүй юм.
- Их нэргүйн гол нь ОХУ-аас хил дамжин урсан орж ирж Жаргалан өндрийн баруун энгэрт Далан тавын хөндийн голтой нийлж монголын нутаг дэвсгэр дээгүүр 13.5 км орчим урсаад шургаж байв. Энэхүү 2 гол нь Улз голын томоохон цутгал Дөч голд нийлдэг байсан байна.
- Хур бороо багатай жилүүдэд урсац шургаж тасардаг ч хур бороо элбэг жилүүдэд томоохон даавар /талиан/ байдлаар урсац Дөч голыг тэтгэх боломжтой байна гэж дүгнэлээ.
- Их Нэргүйн голын татамтай XV-020507 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “ЦЦ эрдэс майнинг” ХХК-ны талбай хэсэгчилсэн байдлаар давхцалтай байна.



Тус аж ахуйн нэгжийн 2 нөөцийн талбайн томоохон хэсэг голын татам дотор бүхэлдээ оршиж буй бөгөөд Их Нэргүйн голын одоогийн голдрилтой хэсэгчлэн давхцаж байгаа юм.

Иймд мэдээллийн сангийн хуучин эх сурвалжийг ашиглан 50 метрт онцгой, 200 метрт энгийн хамгаалалтын бүс тогтооход Усны тухай хуулийн 22.2 дахь заалт /татам/ болон голын голдрилын зураглалын өөрчлөлтөөс болоод зөрчилдөөнд хүрч байна.

ИХ НЭРГҮЙН ГОЛ – ЦЦ ЭРДЭС МАЙНИНГ ХХК

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
ОНОН-УЛЗ ГОЛЫН
САВ ГАЗРЫН ЗАХИРГАА
22120. Дорнод аймаг, Баяндун сум, Наран баг
УБД: 0770001147, Утас: 99207648, 89055788
E-mail: ulz_onon@yahoo.com
2018. 07. 26 № 77.
Танай _____ -нм № _____ -т

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ
ГАЗРЫН КАДАСТРЫН ХЭЛТЭСТ

Улз голын сав газра
аймгийн Баяндун сумын
дэвсгэрт XV-020507
зөвшөөрөлтэй "ЦЦ" Эрдэс Ма
нь ОХУ-аас орж ирдэг Их Н
бүхий газрын хамгаалалтын
давхцалтай байна.

Их Нэргүйн голын
ашиглалтын талбайд
хэмжилтүүдийн үр дүн, г
байдлын талаарх зурган мэд
талаарх мэдээллийг хавсралт

Хувийг: Байгаль орчин аялал ж
Сав газрын удирдагын хэлтэст

Хавсралт 7-н хуудаста

ДАРГА

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
ОНОН-УЛЗ ГОЛЫН
САВ ГАЗРЫН ЗАХИРГАА
22120. Дорнод аймаг, Баяндун сум, Наран баг
УБД: 0770001147, Утас: 99207648, 89055788
E-mail: ulz_onon@yahoo.com
2018. 07. 26 № 76
Танай _____ -нм № _____ -т

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЯАМНЫ ОЙ, УС, ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР
НУТГИЙН КАДАСТРЫН ХЭЛТСИЙН ДАРГА
Н.БАТЗАЯА ТАНАА

Улз голын сав газарт хамаарах Дорнод
аймгийн Баяндун сумын Түргэн багийн нутаг
дэвсгэрт XV-020507 ашиглалтын тусгай
зөвшөөрөлтэй "ЦЦ" Эрдэс Майнинг" ХХК-ны талбай
нь ОХУ-аас орж ирдэг Их Нэргүйн голын усан сан
бүхий газрын хамгаалалтын бүстэй хэсэгчилсэн
давхцалтай байна.



Их Нэргүйн голын татам болон тус
ашиглалтын талбайд хийсэн хээрийн
хэмжилтүүдийн үр дүн, газар дээрх нөхцөл
байдлын талаарх зурган мэдээлэл, усны урсацын
талаарх мэдээллийг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 7-н хуудастай.

ДАРГА

Б.БАЯРТОГТОХ

97 045



МЕРИТ ТӨСЛИЙН ЗӨВЛӨХ ЭНДРЬЮ ШАРПЕ

Хорин таван жилийн туршлагатай байгаль орчны
эрдэмтэн

Чиглэл:

Усны экологи, усны сав бүхий газрын
биологи, тогтвортой төлөвлөлт , байгаль
орчны үнэлгээ, усны чанарын хяналт,
сэргээн засварлах төлөвлөлт,
хэрэгжүүлэлт

Ажил
байдал:

Хувийн сектор, зөвлөх үйлчилгээ
ТББ (Ус цуглуулах талбайн бүлгүүд)
Засгийн газар

Улс орон:

Канад
Англи
Малави



БИ ЖИ ЭМ БИ ХХК

БИ ЖИ ЭМ БИ ХХК – БАЛЖИННЯМЫН БУЛАГ

БАЙГАЛЬ ОРЧИН НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
**ОНОН-УЛЗ ГОЛЫН
САВ ГАЗРЫН ЗАХИРГАА**

22120. Дорнод аймаг, Баяндун сум, 4 дүгээр –
:0770001147, Утас:99006807,95588045

2016.05.20 № 21.

танай _____ -ны № _____ -т

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал
жуулчлалын яамны хүрээлэн буй орчин,
байгалийн нөөцийн удирдлагын
газарт


Түргэн багийн нутаг дэвсгэрт хамрагдах уртраг
113° 27'43.0", өргөрөг 49° 27' 47.2" солбицол бүхий
Балжиннямын булагт "Би Жи Эм Би" ХХК-ны хүсэлтээр
хээрийн хэмжилт хийж үзэхэд уг булаг нь ширгэсэн
бөгөөд урсац бүрэлдэх эхийг тодорхойлох боломжгүй
байсан.

Тухайн булгийн татмын өргөн нь дунджаар 500
– 700 м, намаг, чийг ихтэй тул ашиглалт явуулах
боломжгүй болно.

Хавсралт 1 хуудастай.




152 38



- Дорнод аймгийн Баяндун сумын Хайрхан багийн Би Жи Эм Би ХХК-ийн хайгуулын талбай Балжиннямын булагтай давхцалтай гэж тодорхойлогдсон тул сав газрын захиргаанаас ажлын хэсэг томилж, хээрийн хэмжилт хийсэн.
- Тус булаг нь урсацгүй, даавар газар байсан тул булгийн татмаар хэсэгчилсэн хасалт хийх хүсэлтийг БОАЖЯ-нд хүргүүлсэн байна.


**Усны сан бүхий газрын хамгаалалтын
бүстэй давхцалтай үндэслэлээр хайгуулын
талбай хүссэн өргөдөлд татгалзсан хариу
өгсөн аж ахуйн нэгжүүд**

ТҮРГЭН ГОЛ – ТРОЖАН ХОЛДИНГ ХХК



- Засгийн газрын 2015 оны 289 дүгээр тогтоолыг үндэслэн Ашигт малтмал, газрын тосны газар, БОАЖЯ-ны Кадастрын хэлтсээс усны сан бүхий газрын энгийн болон онцгой хамгаалалтын бүстэй давхцалгүй байна гэсэн 2 лавлагаа гаргаж, Дорнод аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хүргүүлсэн байдаг.
- Онон, Улз голын сав газрын захиргааны зүгээс Усны тухай хуулийн Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 болон *Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан* “**УСНЫ САН БҮХИЙ ГАЗАР, УСНЫ ЭХ ҮҮСВЭРИЙН ОНЦГОЙ БОЛОН ЭНГИЙН ХАМГААЛАЛТЫН, ЭРҮҮЛ АХУЙН БҮСИЙН ДЭГЛЭМИЙГ МӨРДӨХ ЖУРАМ**”-ын 2.3.2 дахь заалтуудыг үндэслэж, татам онцгой хамгаалалтын бүс мөн юм гэж тайлбарлаж, шүүгчийн зүгээс орон нутгийн талд шийдвэр гаргасан.

- Аурора инвестмент ХХК-ийн хайгуулын талбай хүссэн талбайд гаргасан хамгаалалтын бүсийн болон голын голдрилын зөрүүг харуулсан зураглал





ЗҮРХИЙН БУЛАГ – ӨСӨХ ТҮМЭН ХИШИГ ХХК

Дорнод – Баянхонгор сумийн

Онон, Чээсэнь газрын захиргаанд
хүсэлт гаргах нь:

2018-05-14

Наран Бүтэг

Тус сумийн "Яргай Батийн" харьяат
Ч. Энхээ миний бие нь мөн басгийн "Тэмээ үүд",
гэх газрийг "Байгаль хамгаалал", нохорлот
байгуулан хариуцан ажиллаж байна.
Чг хариуцан байгаа талбайд маань О.Т.ХК-ны
хайгуулын өрөмдлөг хийхдээ, Бүтэгийн
эх, үс, голчийн голдротын хүчтэ зорчсон
эсэхэд дүгнэлт гаргаж өгнө үү?

Хүсэлт Бичсэн "Тэмээ үүд", нохорлот-
ийн ахлагч. Ч. Энхээ

2018-05-24-нд
тусуу зүүг нь ашиг
Кордунат талбайгаар
үргэж

2/16-нд
хүсэлт авсан.
Зарим

